

Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн ажиллуулах тухай зар.

Админ 2023-05-22 780

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх

Бүрдүүлэх бичиг баримт:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

Материал хүлээн авах:

Хугацаа: 2023 оны 05 сарын 26-ны өдрийн 17:00 цаг хүртэл

Хүлээн авах: Жагсаалтад бүртгэлтэй тухайн байгууллагын цахим шуудангаар бичиг баримтаа бүрэн бүрдүүлэн илгээнэ.

Шилжүүлэн авах ажлын байрны жагсаалт

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Сул орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод				Утас	Цахим хаяг
					Төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага		
1	Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	Хамралт, орлого шимтгэлийн тасаг	Сайн дурын даатгалын байцаагч	1	Дэс түшмэл	ТЗ-7	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-Нягтлан бодох бүртгэл /041101/ -Санхүү /041201/ -Даатгал /041201/ -Эдийн засаг /031101/ -Менежмент ба удирдахуй /041301-041304/	--Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх" гэснийг хассугай /Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 90 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан	Туслах түшмэлийн ангилалд ажилласан бол давуу тал болно	99170005, 99262089	orhon@ndaatgal.mn
2	Жаргалант сумын ЗДТГ	Санхүүгийн алба	Орон нутгийн өмч хариуцсан мэргэжилтэн	1	Дэс түшмэл	ТЗ-9	Дээд боловсролтой байх	Эдийн засаг, нягтлан бодох бүртгэл, санхүү, банк, бизнесийн удирдлага	Шаардлага тавихгүй	Шаардлага тавихгүй	99360207, 99968253	hi.uuganchim eg@gmail.com

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

